

## **СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ , ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ**

### **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ**

Тусгай зөвшөөрлийг Монгол Улсын “ Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4-р зүйлийн 4.3 дахь заалт, Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2014 оны 10-р сарын 29-ны өдрийн 127 тоот тогтоолыг үндэслэн олгож байна. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж нь дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ . Үүнд:

-Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл / эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрлийн тодорхой дурьдах /

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

- Сумын Засаг даргын санал

- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх газруудыг Худалдааны газар, түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5021-2007, Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946-2005, Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага MNS 5364-2011 улсын стандартын шаардлагыг аймгийн төвд 90% суманд 85% хангасан тухай Мэргэжлийн хяналтын газрын худалдаа, нийтийн хоол, хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын санал дүгнэлт зэрэг болно.

- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт зэрэг болно.

### **Согтууруулах ундаа худалдах , түүгээр үйлчилгээ үзүүлэх**

#### **тусгай зөвшөөрөл олгох журам**

**2.3** Аймгийн комисс нь тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг “Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хуулинд заасан хугацаанд шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

**2.4** Комиссын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамж гарснаар тухайн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгоно.

